

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ

2023 оны ... сарын ... өдөр

Дугаар ___/___

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Шүүх шинжилгээний тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.3 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Яллагдагч, шүүгдэгчийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Тушаалын хэрэгжилтийг зохион байгуулж, үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Шүүх шинжилгээний ерөнхий газрын дарга (цагдаагийн хурандаа Ж.Буянбат)-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль зүй, дотоод хэргийн яамны төрийн нарийн бичгийн дарга (П.Сайнзориг), Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн дарга (Ж.Эрдэмбилэг)-д тус тус даалгасугай.

4.Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан “Сэжигтэн, яллагдагч, шүүгдэгчийг эрүүл мэндийн байгууллагад байрлуулах журам” 2014 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн А/217/423 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД

ЭРҮҮЛ МЭНДИЙН
САЙД

Х.НЯМБААТАР

С.ЧИНЗОРИГ

ЯЛЛАГДАГЧ, ШҮҮГДЭГЧИЙГ ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГАД БАЙРЛУУЛАХ ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1.Энэхүү журмын зорилго нь шүүх эмнэлгийн шинжилгээ хийхийн тулд яллагдагч, шүүгдэгчийг тодорхой хугацаанд эмнэлэгт байрлуулж шинжилгээ хийж, ажиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Шинжээч эмч нь үйл ажиллагаандаа “Шүүх шинжилгээний тухай хууль”, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль” болон энэхүү журмыг мөрдлөг болгоно.

Хоёр. Яллагдагч, шүүгдэгчийг эмнэлгийн байгууллагад байлгах үндэслэл

2.1.Шинжээч эмч яллагдагч, шүүгдэгчийн биед шинжилгээ хийхэд тухайн этгээдийг зайлшгүй эмнэлэгт байрлуулж, оношийг нарийвчлан тогтоолгох шаардлагатай гэж үзвэл эрх бүхий этгээдэд хүсэлт тавина.

2.2.Шинжээч томилох эрх бүхий этгээд энэ тухай үндэслэл бүхий тогтоол гаргаж эмнэлэгт байрлуулах арга хэмжээ авна.

2.3.Яллагдагч, шүүгдэгчийг эмнэлэгт байрлуулсан бол шинжилгээ хийлгэх эрх бүхий этгээд Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2-т заасны дагуу гэр бүлийн гишүүдэд 24 цагийн дотор мэдэгдэх ба энэ тухай шинжилгээ хийлгэх тухай тогтоол, захирамжид тэмдэглэнэ.

2.4.Шинжээч эмч эмнэлэгт байрласан яллагдагч, шүүгдэгчийн биеийн эрүүл мэндийн байдалд ажиглалт хийж, онош бүрэн тогтоогдсоны дараа шинжилгээ хийж, дүгнэлт гаргана.

Гурав. Шинжилгээ хийлгэх этгээдийг эмнэлэгт байрлуулах хугацаа

3.1.Шинжилгээг хийлгэх эрх бүхий этгээд шинжилгээний төрөл, цар хүрээ, онцлогийг харгалзан яллагдагч, шүүгдэгчид шинжилгээ хийх хугацааг тогтооно.

3.2.Шаардлагатай тохиолдолд шинжээчийн үндэслэл бүхий хүсэлтийг харгалзан Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 16 дугаар зүйлийн 13.3-т заасныг үндэслэн шинжилгээ хийх хугацааг сунгаж болно.

Дөрөв. Бусад

4.1.Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.